БАТЛАВ

САЛБАРЫН ДАРГА Т.МӨНХБАЯР

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр №2023/77 Мандалговь хот

1.Техникийн нөхцөл хүссэн хуулийн этгээд болон байгууллага	*Өмнөговь аймгийн Цогтовоо сумын ЗДТГ*
2.Хэрэглэгчийн хаяг:	*Өмнөговь аймаг, Цогтовоо сум, ЗДТГ-ын байр*
3. Хэрэглэгчийн байршил, зэрэглэл:	*Өмнөговь аймаг, Цогтовоо сум, 1-р баг Замын шанд Их хаан 1-100 тоот III зэрэглэл*
4. Ажил үйлчилгээний зориулалт	*Ахмадын өргөө*
5. Техникийн нөхцөл олгох үндэслэл:	*2023 оны 10-р сарын 31-ны өдрийн 23/116 албан тоот*
6. Суурилагдсан чадал:	*Нийт 48 кВт*
7. Холбогдох цэг:	***7.1** АТП-58 дэд станцын фидер №1 төв гаргалгааны ТП№5 щит №47-г өргөтгөж 6 тоолуурын багтаамжтай 0,4кВ-ын 200А-ын ерөнхий рубильник гал хамгаалагч бүхий тулгуурт, гадна байршуулах зориулалттай щитээр солих, щитний оруулгын КШ-ыг АВВГ/3*50+1*35/-аас багагүй хөндлөн огтлол бүхий кабель шугамаар солих, өөрийн тэжээлийг АВВГ/3*50+1*35/-аас багагүй хөндлөн огтлол бүхий кабель шугамаар авах* ***7.2** АТП-58 дэд станцын фидер №1 төв гаргалгааны 7-р тулгуур хүртэл 25 мм^2 ХОТ-той СИП шугамыг 50 мм^2 ХОТ-той СИП шугамаар солих* ***7.3** 0.4кВ хүчдлийн кабель шугамыг 0.5м-ээс багагүй гүнд стандартын дагуу суурилуулж булах*
8.Тоолуур хэмжих хэрэгсэл:	***8.1** Монгол улсын Стандарт хэмжилзүйн үндэсний төвөөс загварын туршилтанд орж, ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан өндөр нарийвчлалтай цахилгаан 3 фазын 100А-ын автоматыг стандартын дагуу монтажлан ээмшлийн заагт байршуулна.*

9. Тусгай заалтууд:

9.1 Шинээр баригдах объектын цахилгаан хангамжийн ажлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн техникийн нөхцөл олгогчоор хянуулна.

9.2 Шинээр баригдах ЦДКШ, байршлын зураг, трассын схемийг Дундговь ЦТС салбарын инженер техникийн ажилтантай хамтран гаргана.

9.3 0.4кВ-ын ерөнхий щитний газардуулгын эсэргүүцлийг "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн 1.6.36-д заагдсаны дагуу 4 Ом-оос ихгүй байхаар газардуулсан байна.

9.4 Хэрэглэгчийн баригдах объект нь бусдын эзэмшлийн газар нутаг, инженерийн байгууламжийг дайрч байвал холбогдох эзэмшигчээс зөвшөөрөл авна. Мөн объектын хамгаалалтын зурвас, газрын зөвшөөрлийн талаар холбогдох байгууллагаас зөвшөөрөл авна.

9.5 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдэлийн түвшингийн ±5%-ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй орчин үеийн шинэ найдвартай тоног төхөөрөмж суурилуулна.

9.6 Цахилгааны оруулга, гаргалгын кабель шугам, барилгын дотор монтаж, угсралтын ажлыг "Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл"-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

9.7 Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай туршилт, хэмжилтийг Дундговь ЦТС салбараар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

10. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

10.1 Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4.22, 4.23-р заалт, "БЗӨБЦТС" ТӨХК-ийн "Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтанд хүлээн авах журам"-ын дагуу цахилгаан түгээх сүлжээнд холбогдоно.

10.2 Цахилгаан тоноглол болон агаарын шугам, кабель шугамын ашиглалт үйлчилгээний талаар "БЗӨБЦТС ТӨХК"–ийн Дундговь ЦТС салбарын шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажиллана.

10.3 Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2 30.1.3 30.1.4 30.1.7 30.1.8-р заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

10.4 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, үйлдвэрлэлийн бус барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10.5 Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.3 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.

10.6 Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

10.7 Энэхүү техникийн нөхцлийн дагуу барилга угсралтын ажлыг хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэн сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН:

ХЯНАСАН:

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:ТҮАХМЕ ИНЖЕНЕР Г.МЯГМАРСҮРЭН

ГИШҮҮД: ЭЭЛЖИЙН АХЛАХ ИНЖЕНЕР Н.ЦЭВЭГДЭЛГЭР

ХҮАХМ С.ЭНХБАТ

РХХТТИ Н.ЭНХБААТАР

БОЛОВСРУУЛСАН: АЗИ Г.МӨНХ-ЭРДЭНЭ

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2022 оны 08 сарын 24-ны өдрийн
А/92 тоот тушаалын Хоёрдугаар хавсралт Маягт-15

MONGOLIA NETCOM
ӨНДӨР ХУРДНЫ ҮНДСНИЙ СҮЛЖЭЭ

БАТЛАВ:
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ДАРГА.....Б.БАЯРАА

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар В-А2023/89

/Өмнөговь аймаг/ 2023 оны 10 сарын 24 өдөр

Захиалагч:АЗДТГазар

Гүйцэтгэгч:Пауэрхаус девелопмент групп ХХК

Харилцах утас: 91969798

Байршил: Цогт-Овоо сумын төвд

Зориулалт: Ахмадын өргөө барих

Холбооны хэрэгцээ: Холбооны стандарт бүхий худаг,сувагчлал хийх

Шилэн кабель 12 кор

1. **Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгогдсон харилцаа холбооны үндсэн сүлжээ байгуулах эрхийнхээ дагуу техникийн нөхцлийг зөвхөн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК олгоно. Техникийн нөхцөлгүйгээр холбооны худаг сувагчлал байгуулах, кабель татах, шилжүүлэх тохиолдолд уг барилга обьектыг техникийн комисс болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

2. **Техникийн үндсэн нөхцөл:**

Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутаг дэвсгэрт шинээр баригдахаар төлөвлөж буй Ахмадын өргөөний барилгыг холбоожуулахад дараах техникийн нөхцөлийг олгож байна.

2.1 Цогт-Овоо сумын ЗДТГазраас шинээр төлөвлөж буй Ахмадын өргөөний барилга хүртэл чанар, стандартын шаардлага хангахуйц 100мм-ийн диаметртэй PVC хоолойгоор 2 эгнээтэй сувагчлал хийж 100м тутамд болон булан тохой, байшингийн оруулгад холбооны стандартын худаг/ТБУХ1/ суурилуулна.

2.2 СЗДТГазрын байрны техникийн өрөөнөөс 12 корын шилэн кабелийг шинээр хийсэн худаг, сувагчлалаар дайруулан татаж, серверийн өрөөнд оруулан шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмж 12 корын FDF-д цэнэглэнэ. FDF-ийг стандартын дагуу суурилуулна.

2.3 Дохиолол, домофон систем, телефон холбоо, кабелийн телевиз, интернэт, хяналтын систем, шинэ үйлчилгээний тоног төхөөрөмжүүдийг байршуулах техникийн өрөөг зайлшгүй төлөвлөх шаардлагатай.

3. **Зураг төсөлд зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцөлүүд:**

3.1 Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2013, MNS 5279:2013, MNS 5280:2003, MNS 6668:2017, MNS 6581:2016, MNS 3966:2017, MNS 6305:2012, MNS 4908:2017, MNS 5532:2005 ерөнхий шаардлагууд болон 2019 онд шинэчлэн батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 5-р зүйлд заасны дагуу гүйцэтгэх

3.2 Хэрэглэгчийн шугамын угсралтын ажил барилгын зураг төсөвт байхгүй болон хийгдээгүй бол захиалагчид мэдэгдэж зураг төсөвт оруулах.

3.3 Кабелийн хуваарилах хайрцагны байрлалыг хэрэглэгчийн шугамын нягтралын цэгт болон техник ашиглалтын шаардлага хангахуйц байдлаар сонгон суурилуулахаар технологийн норм хэмжээг зааж оруулах.

3.4 Дээрх техникийн нөхцөлийн дагуу ажлын зураг гүйцэтгэхдээ тухайн ашиглалт хариуцсан газар нэгжээр техникийн шийдлийг хянуулан, зөвшилцөж батлуулна. (Утас: 70532110)

3.5 Угсралт суурилуулалтын ажлыг Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлнэ.

3.6 Шинээр хийх сувагчлалын трасс хийх ажлын зургийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын болон инженерийн шугам сүлжээтэй газруудын холбогдох албан тушаалтнаар шалгуулан баталгаажуулсан байх.

4. **Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:**

4.1 Техникийн нөхцөл, ажлын зураг төсвийн дагуу угсралтын ажил эхлэхээс өмнө Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн ашиглалт хариуцсан газар, нэгжээс ажил эхлэх зөвшөөрлийг авч тухайн ашиглалт хариуцсан газар, нэгжийн хяналтан дор гүйцэтгэнэ.

4.2 Газар шорооны ажил эхлэхийн өмнө ГХБХБГ-ын мэргэжилтнээр трассын зургийг хянуулан зөвшөөрөл авсан байх.

4.3 Газар шорооны ажил гүйцэтгэхдээ тухайн харьяалагдах газар нэгжээр шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актад хавсаргах.

4.4 Шинээр татсан кабель болон FDF-д тэмдэглэгээг бүрэн хийсэн байх.

4.5 Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулж ажиллах.

4.6 Хэрэглэгч холбох нөхцөлийг бүрдүүлэхийн тулд барилгын дотор монтажийн угсралтыг Монгол Улсын стандарт MNS 6581:2016 ерөнхий шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

4.7 Шинээр хийгдсэн худаг сувагчлалын байгууламжийг "Шугам сүлжээний гүйцэтгэлийн зураглалыг шалгаж баилга хот байгуулалтын мэдээллийн санд хүлээн авсан акт", CD-ний хамт ашиглалтын байгууллагад хүлээлгэж өгсний үндсэн дээр худаг сувагчлалын гүйцэтгэлийн зургийг гаргуулна.

5. **Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:**

5.1 Шинээр суурилуулсан худаг сувагчлалын байгууламжийг гүйцэтгэлийн актаар хүлээлгэн өгснөөр ашиглалтын явцад гарах засвар үйлчилгээг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь хариуцна.

5.2 Уг худаг сувагчлалын байгууламж нь цааш үргэлжлүүлэн төлөвлөх, засвар үйлчилгээ хийх, мөн харилцаа холбооны бусад үйлчилгээний зориулалтаар шилэн кабель шинээр суурилуулах зэрэг нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх.

6. **Техникийн нөхцөлийг: Пауэрхаус девелопмент групп ХХК-ний 2023 оны 10 сарын 09-ны өдрийн 23/105 тоот албан хүсэлтийг үндэслэн олгов.**

7. Угсралтын ажил дууссаны дараа Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний хариуцсан нэгжээр хэмжилт шалгалт хийлгэж, техникийн актаар хүлээлгэн өгснөөр сүлжээнд холбогдох боломжтой.

8. Энэхүү техникийн нөхцөл нь батлагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна. Техникийн нөхцөлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгалтыг олгоно.

Хянасан: А.Нарантунгалаг/ Ерөнхий инженер /

Боловсруулсан: Э.Учралтбямба / Кабель шугамын Инженер /

БАТЛАВ: Говийн нарны илч ОНӨААТҮГ-ын захирал Р.Эрдэнэтөгс

Говийн нарны илч ОНӨААТҮГ-ын Техникийн нөхцөл олгох комиссын 2023 оны 10–р сарын 24-ны өдрийн хурлаар хэлэлцэн 04 тоот протоколыг үндэслэн зөвшөөрөв.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ №2023/03

1. Барилга объектын нэр: **Өмнөговь аймгийн Цогт-Овоо суманд Ахмадын өргөөний шинээр баригдах барилгын дулаан болон цэвэр, бохир усны шугам.**

2. Барилга объектын байршил: **Өмнөговь аймаг Цогт-Овоо сумын "Говийн буян дэлгэрэх" ХКХ-ны байрны зүүн хойд талд**

3. Дулааны шугамын холболт хийх байршил, өндөржилт шугамын диаметр:

4. ДХ-3 худгаас хойш ф-159х4мм-н ган төмөр шугамнаас Ф-50х4мм-н зузаантай ган төмөр хоолойгоор 7метр /завод лоткитой/ сувагжилттайгаар хийх. /Дулааны тоолуурыг барилга дотор үзелийн өрөөнд байршуулах/

5. Цэвэр усны тооцоо:
   a. Унд ахуйн хэрэгцээ: 0,8 м3/хоног
   b. Галын хэрэгцээ: 10,0 л/сек

6. Цэвэр усны холболт хийх байршил, өндөржилт шугамын диаметр:
   - ДХ-3 худгаас объект хүртэлх 7 метр Ф76 мм-н ган төмөр хоолойноос Ф-40 мм-н зэвэрдэггүй ган төмөр хоолойгоор дулааны шугамын сувагжилтанд хамт байхаар хийх. /Усны тоолуурыг барилга дотор үзелийн өрөөнд байршуулах/

7. Бохир усны тооцоо:
   Унд ахуйн хэрэглээнээс гарах 0,8 м3/хоног

8. Бохир усны шугамын хоболт хийх байршил, өндөржилт шугамын диаметр:
   - Барилгаас 5метрт Ф100 мм-н хоолойгоор угсралт хийж шинээр ажлын худаг байгуулах. Ажлын худгаас 30 метр Ф-100мм-н бохир усны хоолойг зориулалтын дулаалгаар дулаалж /Цагдаагын хэсгийн баруун урд худаг/ БУХ-67 худагт холбох.
   - Бохир усны шугам нь сумын төвийн засмал зам, явган хүний зам, дугуйн зам доогуур тавих тул холбогдох зөвшөөрлийг ЗДТГазраас авах.

9. Дулаан хангамжийн эх үүсвэр: 2,5мВт –ын 2ш зуух, нийт 5мВт

10. Усан хангамжийн эх үүсвэр: Төвлөрсөн шугам сүлжээ.

11. Захиалагч ба зураг төслийн байгууллагууд нь техникийн норм, дүрмийг баримтлах ба шугам хоолойн холболтын зураг төслийг Говийн нарны илч ОНӨААТҮГазартай зөвшилцөх шаардлагатай.
12. Дулаан, цэвэр усны шугамын зураг төсөвд туршилт тохируулгын ажлын зардлыг тусгах.
13. Энэ техникийн нөхцлийн хугацаа нь 1 жил байна. Хугацаа дууссан үед захиалагч байгууллага нь Говийн нарны илч ОНӨААТҮГазарт хугацааг сунгах буюу дахин шинээр техникийн нөхцөл авах асуудлыг тавина.
14. Шугамын угсралтын ажлын явцад холболтын зураг төсөвт өөрчлөлт орох шаардлага гарвал Говийн нарны илч ОНӨААТҮГазарт хянуулж, зохиогчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.
15. Ажлын зураг төсвийн нэг хувийг хавсрагдах баримт бичгүүдийн хамт Говийн нарны илч ОНӨААТҮГазрын архивт өгнө.
16. Дулаан цэвэр усны шугамын угсралтын үед газар доорх шугам сүлжээг зөөх, дайрч гарах, зам талбай, хашаа бут сөөг эвдэх тохиолдолд сэргээхэд гарах зардлыг төсөвт тусгана.
17. Ус, дулааны тоолуур, хэмжүүрийн зангилааг барилга дотор үзелийн өрөөнд хайрцагт хийнэ.
18. Техникийн нөхцөл олгохтой холбоотой тавигдах шаардлага:
    1. Ус бага зарцуулах тоног төхөөрөмж тавих
    2. Ажлын зураг хийлгэж Говийн нарны илч ОНӨААТҮГазар, сумын ЗДТГ-тай зөвшилцөх.
    3. Барилга дотор галын усны хайрцаг байрлууллах
    4. Цэвэр ус, дулааны шугам дээр Монгол улсын Стандартчлал, хэмжил зүйн газарт баталгаажуулсан тоолуур, манометр суурилуулах
    5. Тоолуурын заалтыг унших нөхцлөөр хангах, тоолууртай хайрцаг нь цоож хамгаалалттай байх
19. Гүйцэтгэгч нь шугамын холболт хийхдээ Говийн нарны илч ОНӨААТҮГазрын техникийн ажилтанаар байнга хяналт тавиулж хяналтын карт хөтлөн ажиллана.
20. Шугамын шахалт, туршилтын үед техникийн ажилтныг заавал биечлэн байлцуулж ил, далд ажлын акт хөтөлнө.
21. Техникийн нөхцөлд тусгасан заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд шугам хоолойг ашиглалтанд хүлээн авахгүй, цэвэр ус, дулаан нийлүүлэх боломжгүй.
22. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 11.1.3-т зааснаар хангагч нь хэрэглэгчийн шугамнаас дамжуулан шинээр хэрэглэгч холбох техникийн нөхцөл олгосон тохиолдолд татгалзахгүй холбуулах.

23. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 11.4-т зааснаар Техникийн нөхцөлд тусгагдсан шаардлагыг зөрчихийг хориглоно.
24. Хэрэглэгч холбох цэгийн шугам хоолойн өмчлөгч нь **ЗДТГ** цаашид хариуцах газар болно.

Говийн нарны илч ОНӨААТҮГ-ын техникийн ажилтан: ..... /Т.Хадбаатар/